



**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 07 сарын 18

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /“АТҮТ”/ ТӨҮГ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“АТҮТ” ТӨҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 88.6%-тай байна.

Яамнаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, холбогдох харьяа байгууллагуудыг хэрэгжүүлэгч байгууллагаар тогтоогоогүй тул эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээнд оруулаагүй болно.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. “АТҮТ” ТӨҮГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн байдлыг хүснэгтэд үзүүлэв.

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Үнэлээгүй Хугацаа болоогүй	
65	36	11	4	5	7	-	2	84.6%

“АТҮТ” ТӨҮГ нь 2025 онд 9 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан ажиллаж байна.

Нийт 65 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 36 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 11 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 4 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 5 арга хэмжээ, 30%-ийн биелэлттэй 7 арга хэмжээ, хугацаа болоогүй 2 арга хэмжээ, дунджаар 84.6%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	Биелэлт	Хувь
“30” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ				



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

1	Арга хэмжээ 1.2. Улс хоорондын зорчигчийн тогтмол тээврийн батлагдсан чиглэлд үйлчилгээг эхлүүлэх	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ 50-аас доошгүй хувь хэрэгжсэн байна.	"Тал нутгийн Хэрлэн" ХХК-аас 2025.03.21-ний өдрийн 17 тоот албан бичгээр "Монгол улсын Дорнод аймгийн Хэрлэн сумаас БНХАУ-ын ӨМӨЗО Хөлөнбуйр аймгийн Хайлаар хот" чиглэлд БНХАУ-ын "Hulunbuir New Silk Road Travel Agency" Co.LTD компанитай хамтран улс хоорондын зорчигчийн тогтмол тээвэрлэлт гүйцэтгэх хүсэлтийг ирүүлсэн бөгөөд холбогдох судалгааг хийж, ӨМӨЗО-ны Зам харилцаа, тээврийн тэнхимд 2025.04.02-ны өдрийн 01/375 тоот албан бичгээр тээвэрлэлт эхлүүлэх хугацааг тодорхой болгож, ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн. ӨМӨЗО-ны Зам, харилцаа тээврийн тэнхимээс хариу ирүүлээгүй бөгөөд хариу ирүүлсэн тохиолдолд тээврийн үйлчилгээг эхлүүлэх бүрэн боломжтой. Төлөвлөгөөний хэрэгжилт 50%-тай байна. /Төлөвлөгөөг хавсаргаа/	30%
2	Арга хэмжээ 1.7. Улс, хот хоорондын нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлт хийхэд хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах	Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн асуудлаар судалгаа хийж, холбогдох банк, санхүүгийн байгууллагуудад санал хүргүүлнэ.	Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвд энэ чиглэлээр судалгаа хийх хүсэлтийг гарган судалгааны төлөвлөгөөг хамтран гаргаж батлуулахаар ажиллаж байна. Парк шинэчлэлтэй холбоотой төрөөс хүсэж буй зээлийн хэмжээ, хөнгөлөлтийн нөхцөлийн талаарх судалгааг тээвэрлэлт гүйцэтгэдэг улс, хот хоорондын 39 ААНБ-аас авч эхний байдлаар ЗТЯ-ны АТБЗГ-ын мэргэжилтэн н.Чүнсэрээд цахим хэлбэрээр хүргүүлсэн. Мөн 2025.04.07-11-ний өдрүүдэд БНХАУ-ын "Yutong" ХХК-ийн автобусны үйлдвэртэй газар дээр нь танилцаж, холбогдох удирдлагуудтай хөнгөлөлттэй зээлийн үнээр автобус авах боломжийн судалгааг хамтран хийхээр тохиролцсон бөгөөд хамтарсан судалгааг хийж байна. Энэхүү судалгаагаар аж ахуйн нэгж байгууллагууд парк шинэчлэлтээр хэрэглэгдэж байсан автобус бус цоо шинэ үйлдвэрлэгдсэн автобусыг худалдаж авах боломж, эдийн засгийн үзүүлэлтүүдийг гаргах бөгөөд судалгаанд үндэслэн банк, санхүүгийн байгууллагад хандахаар бэлтгэж байна.	30%
3	Арга хэмжээ 1.10. Улаанбаатар хотоос 21 аймаг, орон нутгаас Улаанбаатар хот чиглэлд хийгдэж байгаа ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн сан бүрдүүлэх	УБ-аас 21 аймаг, орон нутгаас УБ чиглэлд хийгдэж буй ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	Зам, тээврийн хөгжлийн төвийн төлбөр хураах цэгээр дамжуулан УБ хотоос 21 аймаг, орон нутгаас УБ хот чиглэлд хийгдэж байгаа ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх зорилгоор ЗТЯ-ны АТБЗГ-тай 2025.04.01-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Дээрх асуудлаар 2025.04.03-ний өдөр тус үйлдвэрийн газрын Ачаа тээврийн хэлтсийн дарга О.Энхбат Ерөнхийлөгчийн зөвлөхтэй уулзаж мэдээлэл өгч, Гаалийн өрөнхий газартай хамтран ажиллах чиглэл авч, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дорноговь аймгийн Замын-Үүд боомтоор орж ирж байгаа импортын ачаа тээврийн мэдээллийг бүртгэлжүүлэн мэдээллийн сан үүсгэх зорилгоор Хил гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах санал	30%



			солилцон мэдээлэл дамжуулах схем боловсруулан ажиллаж байна.	
4	Арга хэмжээ 2.6. Аймаг, нийслэл дэх ТХУ-ийн төвүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах	I-II улирал Аймаг, нийслэлийн 3 техникийн хяналтын үзлэгийн төвийг итгэмжлэлд хамруулна.	Тус үйлдвэрийн газраас Үндэсний итгэмжлэлийн төвд 2025 оны 02 дугаар сард Архангай, Увс, Завхан, Ховд, Баян-Өлгий аймгийн автотээврийн төвүүд анхан итгэмжлэл материал Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн автотээврийн төвүүд давтан итгэмжлүүлэх хүсэлтийг тус тус хүргүүлсэн. Эдгээр хүсэлтийн хариуд Үндэсний итгэмжлэлийн төвөөс "Нэгдсэн зохион байгуулалтад оруулах тухай" албан бичгээр хариу өгч манай материалыг буцаасан. Итгэмжлэгдээгүй байгаа Архангай, Баян-Өлгий, Увс, Завхан, Ховд, Дархан-Уул аймгийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн итгэмжлэлийн өргөдлийн материалыг бүрдүүлэн итгэмжлүүлэх хүсэлтийг Үндэсний итгэмжлэлийн төвд 2025.03.31-ний өдрийн 1/367 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тухайн хүргүүлсэн хүсэлтийн дагуу хариу албан бичиг ирээгүй. 2025.06.15-ны байдлаар итгэмжлэгдээгүй байгаа нийт 24 техникийн хяналтын үзлэгийн төвийн итгэмжлэлийн өргөдлийн материалыг дахин бүрдүүлэн Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэхээр ажиллаж байна.	30%
5	Арга хэмжээ 3.1. Орон нутагт зорчигч тээврийн автобуудал байгуулах	I-II улирал: Говь-Алтай, Замын-Үүд сумын зорчигч тээврийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. Шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж, Ховд аймгийн зорчигч тээврийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 90%-д хүргэнэ. Замын-Үүдийн автобуудлын барилгын барьж ашиглах хувийн хэвшлийн аж	Замын-Үүд: Тус үйлдвэрийн газрын 2024 оны урсгал зардлын төлөвлөгөөнд тусгагдсан "Замын-Үүд суманд шинээр баригдах автотээврийн төвийн барилгын хүчитгэлийн зураг болон төсөв шинэчлэх" үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар цахим хэлбэрээр нийт 5 удаа зарлаж 2024.06.04-ний өдөр нээлт хийсэн. Тус тендэрт 2 компани буюу "Тэмжин" ХХК, "Пико Инженеринг" ХХК нараас тендерийн материал ирүүлсэн бөгөөд "Тэмжин" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Гүйцэтгэлийн шатандаа явж байна. Зураг төслийн ажлыг бүрэн дуусгаж ЗТЯ-нд хүлээлгэж өгөн хамтран ажиллах болно. Говь-Алтай: Говь-Алтай аймагт автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд нийт 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр барьж байгуулахаар тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд "Мөрөн-Алтай" ХХК шалгарч ЗТХЯ-тай гэрээ байгуулсан. Тус барилгын ажил явагдах газар болон зураг төсөвт өөрчлөлт орсны улмаас барилгын ажил эхлээгүй байна. Зураг төсөвт яаралтай өөрчлөлт оруулан зургийн ажлыг бүрэн дуусгасан. Барилга эхлүүлэх зөвшөөрлийг аймгийн Хот байгуулалт, газрын харилцааны	30%

		ахуйн нэгжтэй гэрээ байгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. Говьсүмбэр аймагт автобуудал барьж ашиглах хувийн хэвшлийг сонгон гэрээ байгуулна.	газраас авч, барилгын ажил эхэлсэн бөгөөд 30 хувийн гүйцэтгэлтэй байна. Говьсүмбэр: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих талаар үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т хүсэлт гаргаж, ЗТХЯ-наас дэмжлэг авч, шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийн автобуудал барилгын ажил эхлээгүй газрын асуудал яригдаж байна 2023.11.08-ны өдөр "Өв хангамж групп" ХХК-тай уулзалт хийж, тус компаниас ТӨБЗГ-т албан бичиг хүргүүлсэн. "Өв хангамж групп" ХХК-аас тус үйлдвэрийн газарт холбогдох тооцоо судалгааг гаргаж, ирүүлээгүй байна. Ховд: ЗТХЯ, ТӨБЗГ, "Автотээврийн үндэсний төв", "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн ажлын хэсгийг тус үйлдвэрийн газрын захирлын 2024.03.22-ны өдрийн А/75 дугаар тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хэсэг "Зорчигч тээврийн Ховд" ХХК-ийн өөрийн хөрөнгөөр Ховд аймагт барьж байгаа автобуудал барилга байгууламжтай 2024.04.02-03-ны өдрүүдэд танилцаж тус аймагт ажилласан бөгөөд ажлын хэсгийн санал зөвлөмжийг үйлдвэрийн газрын захиралд ирүүлснийг 2024.05.02-ны өдрийн 1/523 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Ховд аймгийн зорчигч тээврийн барилгыг 100 хувь ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	
6	Арга хэмжээ 3.3. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга шинээр барих	Барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 30%-д хүргэнэ.	Тус техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгын зураг, төслийн ажил хийгдэж байна. Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас барилгын техникийн нөхцөл, архитектур төлөвлөлтийн даалгавар хоцорч ирсэн тул зургийн ажил дуусаагүй байна.	30%
7	Арга хэмжээ 5.9. Улс, хот хоорондын нийтийн тээврийн жолооч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах.	ААНБ-ын жолооч, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж эхэлсэн байна.	Улс, хот хоорондын нийтийн тээврийн жолооч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зорчигч тээврийн төвүүдтэйгээ хамтран ЭМЯ-нд саналыг хүргүүлсэн. Мөн хувийн эмнэлэгүүдийн үнэ, үйлчилгээний багцын мэдээллийг судалж байна. Багцын шинжилгээний үнэ хэтэрхий өндөр байгаагаас шалтгаалан аж ахуйн нэгж байгууллагууд бүх жолооч нарыг хамруулахад эдийн засгийн хувьд хүндрэлтэй байгаа тул 3 насны бүлэг тогтоож нэг аж ахуйн нэгж байгууллагаас тухайн насны бүлэгт тохирсон 3 жолоочийг сонгон нийт 150 жолоочийг хамруулахаар судалгааг гаргасан.	30%
1	Арга хэмжээ 1.1. Улс хоорондын зорчигчийн тогтмол тээврийн	I-II улирал: 0,3 сая зорчигч тээвэрлэсэн байна.	Улс хооронд 2025.01.01–2025.06.15-ны өдрийн байдлаар 6627 тээврийн хэрэгслээр 121,465 зорчигч тээвэрлэсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34%-иар буурсан байна. Суудал ашиглалт дунджаар 49,2%-тай байна.	50%



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	үйлчилгээг зохион байгуулах			
2	Арга хэмжээ 1.9. БНХАУ-тай шинэчлэн байгуулсан хэлэлцээрийн хүрээнд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх	I-II улирал: Хоёр талын хамтарсан хорооны хурлын товыг тохирч, бэлтгэл ажлыг хангана.	Хоёр талын хамтарсан хорооны хурлыг 2025 оны 6-р сард Монгол улсад зохион байгуулахаар БНХАУ-ын ЗТЯ-тай цахимаар тохиролцож, бэлтгэл ажлыг хангаж байна. ЗТЯ-наас 2025.06.29-ний өдөр зохион байгуулах болсон талаар мэдээллийг тус үйлдвэрийн газарт өгсөн боловч дахин хойшлогдсон, хугацаа тодорхой болохоор чиглэл өгөх талаар мэдэгдсэн.	50%
3	Арга хэмжээ 1.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	Зорчигч үйлчилгээний автобуудлыг ХБИ-д хүртээмжтэй байдлаар тохижуулах ажлыг зохион байгуулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорчигч үйлчилгээний авто буудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар тохижуулах ажлыг зохион байгуулахаар "Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төв" ТББ-тай хамтран төлөвлөгөөний саналыг авч, боловсруулан ажиллаж байна. "Түгээмэл хөгжил" ТББ-тай хамтран 2025.05.26-ны өдөр Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд "Дэд бүтэц хүртээмжийн үнэлгээ"-г хийлгэсэн. Үнэлгээний дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарч тохижуулах ажлыг хийж байна.	50%
4	Арга хэмжээ 7.2. Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, гурван улсын хамтарсан хорооны уулзалтад оролцох	Гурван улсын хамтарсан хорооны 2025 оны уулзалтын бэлтгэл хангах, экспертүүдийн уулзалтад тээвэрлэлтийн мэдээллээр хангасан байна.	Хамтарсан хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг тохирох, хурлын тов тогтох уулзалтыг ЗТЯ-наас 2025.05.26-ны өдөр онлайнаар зохион байгуулсан. Уулзалтад ОХУ-ын ЗТЯ оролцож, хурлын протоколыг урьдчилан тохирох уулзалтыг 2025.06.17-ны өдөр цахимаар хийх, Хамтарсан хорооны уулзалтыг 2025.06.30-ны өдөр Улаанбаатар хотноо хийхээр тохиролцсон.	50%
5	Арга хэмжээ 7.3. ЗТЯ-наас зохион байгуулах Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах хамтарсан хорооны хуралд оролцох	Хамтарсан хорооны хуралд оролцсон байна.	Хугацаа болоогүй. ЗТЯ-наас зохион байгуулна. ЗТЯ-наас 2025.06.29-ний өдөр зохион байгуулах болсон талаар мэдээллийг тус үйлдвэрийн газарт өгсөн боловч дахин хойшлогдсон, хугацаа тодорхой болохоор чиглэл өгөх талаар мэдэгдсэн.	50%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин			Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

13	12	1	0	92.3%
----	----	---	---	-------

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-09, Дугаар 2025_16

Хэрэгжүүлэх заалт: 16.20.2.2. Нүүрс тээвэрлэлтийн төмөр замын тээврийн тарифыг автотээврийн тарифтай өрсөлдөхүйц хэмжээнд бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг яаралтай авч ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд;(Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, гадаад валютын улсын нөөцийн нөхцөл байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав:

Биелэлт: Дээрх асуудлыг одоогоор судалж байна.

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
17	14	3	-	-	82.35%

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2024.01.25 №А/23

Хэрэгжүүлэх заалт: 1.Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны С/02 дугаар тушаалаар "Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартын холбогдох заалтуудыг түр түдгэлзүүлсэнтэй холбоотойгоор улс, хот хоорондын болон нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийслэлийн Нийтийн тээврийн газар (Д.Отгонжаргал), "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ (Б.Гүрсоронзон)

Биелэлт: Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн ААНБ-уудад 2024.02.20-ны өдрийн 1/174 тоот бичгийг хүргүүлэн тээврийн үйлчилгээний тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн аюулгүй байдлын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Зорчигч тээврийн бүртгэлийн системд 2011 оны 76 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд 2024.06.10-ны өдрийн байдлаар 76 тээврийн хэрэгсэл буюу 100% нь техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна. /Биелэлт шинэчлэх хуучин тоо баримт байна/

2. **Хэрэгжүүлэх заалт:** 1.2.Стандартын түдгэлзүүлсэн заалтад хамаарах автобусны техникийн хяналтын үзлэгийг зөөхөн суурин төвд, камерын хяналт дор зохион байгуулж, дүрс бичлэгийг баримтжуулж хадгалах

Биелэлт: Биелэлт ирүүлээгүй.

3. **Хэрэгжүүлэх заалт:** 1.3.Техникийн хяналтын үзлэг гүйцэтгэхдээ, бүхээг, эд ангиудын зэврэлт, салхины шилний тунгалаг чанар, нум, амортизаторын ажиллагаа, утааны найрлага дахь хорт хийн түвшний хэмжээ, ажлын тоормос, жолооны механизм, гэрэлтүүлэх хэрэгсэл зэрэг хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд ангиудын техникийн байдалд анхаарч дүгнэлт гаргах;

Биелэлт: Техникийн хяналтын үзлэг гүйцэтгэхдээ бүхээг, эд ангиудын зэврэлт, салхины шилний тунгалаг чанар, нум, амортизаторын ажиллагаа, утааны найрлага дахь хорт хийн түвшний хэмжээ, ажлын тоормос, жолооны механизм, гэрэлтүүлэх хэрэгсэл зэрэг хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд ангиудыг сайтар шалгаж, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн ААНБ-д мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Төсөв/гүйцэтгэл	9	8	-	1	-		92.2%
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	5	-	-	-		100%
бусад	8	8	-	-			100%
Нийт	22	21	-	1	-		97.4%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Хэсэг	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ /Хувиар/
		100	70	30	0		
1	10	2	3	2	1	2	58.75
2	6	4	2	0	0	0	90.00
3	14	11	1	0	0	2	97.50
4	2	0	1	0	0	1	70.00
5	13	6	1	0	0	6	95.71
Нийт	45	23	8	2	1	11	85.88

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ

- 1/ 1.3. Эдийн засаг, хөгжлийн үзүүлэлт, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт тавих, өөрийн сайтад байршуулах.
- 1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт хэсэгт мэдээлэл шинэчлэн байршуулах.
- 1.7. Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн байршуулах.
- 1.8. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан мэдээг шинэчлэх.
- 1.9. Сар удирдал жилээр мэдээлэл, тайлан гарч байгаа тул шинэчлэн байршуулах.
- 1.10. Мэдээлэл хариуцагчаас тухайн жил зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр батлуулж, сайт дээр мэдээлэх.
- 2/ 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журамтай болох.
- 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журамтай болох.
- 2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай бүр мэдээлэх.
- 3/ 3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тухай бүр оруулах.
- 3.11. аудит бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг оруулах, өөрийн сайтад байршуулах.
- 4/ 4.1. Мэдээлэл шинэчлэх.
- 5/ 5.5. Ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг мэдээлэл байршуулах.

ГУРАВ: Үнэлэлт, дүгнэлт

3.1. Төлөвлөлтийн байдал:

"АТҮТ" ТӨҮГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг стратеги төлөвлөгөө, зорилтот түвшинг холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлсэн, салбарын хэмжээнд эрх зүйн орчинг боловсронгуй болгох болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиглэлээр үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, оновчтой тодорхойлох.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам" шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.



3.2. Хэрэгжилтийн байдал:

1) "АТҮТ" ТӨҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 88.6%-тай байна.

2) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 65 арга хэмжээнээс 74.6% нь хүрэх түвшиндээ хүрсэн буюу хүрч байгаа, 25.4% нь төлөвлөсөн түвшиндээ хүрээгүй, 2 арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

3) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт бүрээр нь харуулбал:

№	Зорилтууд	Арга хэмжээн-ий тоо	Хэрэгжилтийн хувь
1	Зорилт 1. Автотээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.	12	69.16%
2	Зорилт 2. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	8	88.75%
3	Зорилт 3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	5	62%
4	Зорилт 4. Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлнэ.	7	97.14%
5	Зорилт 5. Эрх зүйн болон хөгжлийн бодлогын баримт бичиг тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	12	91.66%
6	Зорилт 6. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, нийгмийн асуудал, сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадвар олгоход чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын агуулга, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.	6	96%
7	Зорилт 7. Улс хоорондын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	4	56.66%
8	Зорилт 8. Тээврийн хэрэгсэл эзэмшигч, иргэн хуулийн этгээдийн хариуцлагыг дээшлүүлж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.	9	93.75%
9	Зорилт 9. Иргэн аж ахуйн нэгжид тохирлын үнэлгээ хийж, чанарын дэд бүтцийг бэхжүүлнэ.	2	100%

4/ Эхний хагас жилийн байдлаар улс хооронд 6627 тээврийн хэрэгслээр 121,465 зорчигч тээвэрлэсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34%-иар буурсан байна. Суудал ашиглалт дунджаар 49,2%-тай байна. Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээгээр 30,519 тээврийн хэрэгслээр өссөн дүнгээр 692,940 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5%-ийн өсөлттэй байна. Суудал ашиглалт 74%-тай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

"АТҮТ"ТӨҮГ-ын 2025 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1. Улаанбаатар хотоос 21 аймаг, орон нутгаас Улаанбаатар хот чиглэлд хийгдэж байгаа ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн сан бүрдүүлэх, Орон нутагт зорчигч тээврийн автобуудал байгуулах зорилт арга хэмжээг эрчимжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан автотээврийн салбарын эрх зүйн баримт бичгийн төслийг бүрэн боловсруулж ажиллах;



4.2. БНХАУ-тай шинэчлэн байгуулсан хэлэлцээрийн хүрээнд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх, Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, гурван улсын хамтарсан хорооны уулзалтад оролцох зорилт арга хэмжээний хүрээнд байгууллагын үүрэг оролцоог тайлагнах, Улс хоорондын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээний суудал, ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр судалж ажиллах;

4.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах;

4.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахдаа арга хэмжээний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг тус тус зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

АВТО ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Э.МӨНХНАСАН

"АТУТ" ТӨҮГ-ЫН ДАРГА

Б.ГҮРСОРОНЗОН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Я.ГАНЦЭЦЭГ



**“АТҮТ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/хүснэгтээр/

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	65	63	84.6%
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	12	12	93.2%
3	Сайдын тушаалын биелэлт	17	17	82.35%
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	22	22	97.4%
5	Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ	45	45	85.88%
Нийт		161	159	88.6%

**“АТҮТ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/Графикаар/

